



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 5/22

Хэрлэн сум

Б.Жавхланбаярыг Батноров сумын  
Засаг даргаар томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 56 дугаар зүйлийн 56.6, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны "Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтад заасан шаардлагыг хангасан Баярцогтын Жавхланбаярыг Батноров сумын Засаг даргаар томилсугай.

2. Сумын Засаг дарга Б.Жавхланбаярын үндсэн цалинг 1,052,207 /нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон/ төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцож цалинжуулахыг Батноров сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Б.Жавхланбаярт томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ харьяа Эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

20220523

Аймгийн Засаг даргын 2022 оны  
... дугаар сарын ... өдрийн .....  
... дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Томилолт	11 хүн 3 хоног	26,500*33	874,500
2	Шатахуун- АИ-92	800 (2 машин *320 л)	2,520	806,400
3	Шатахуун /Дизель /	800 (1машин *160 л)	3380	540,800
4	Ахмад настан, малчдад хүндэтгэл үзүүлэх			581,800
Дүн				2,803,500